



ДОРНОГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

Дорноговь аймгийн
нийгэм, эдийн засгийн
танилцуулга

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТАНИЛЦУУЛГА

2020/08



Мэдээллийн нэгдсэн лавлах: WWW.1212.MN

ГАРЧИГ

Товч танилцуулга.....	1-14
Нийгэм, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	15
Нэг. Эрүүл мэнд.....	16-17
Хоёр. Хөдөлмөр эрхлэлт	18-20
Гурав. Нийгмийн даатгал, халамж.....	21-24
Дөрөв. Гэмт хэрэг.....	25-26
Тав. Мөнгө,зээл	27
Зургаа. Төсөв, санхүү	28-29
Долоо. Үнэ.....	30-33
Найм. Хөдөө аж ахуй	34-36
Ес. Аж үйлдвэр.....	37-41
Арав. Байгаль орчин	42

ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

(2020 оны 08 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт




1.1 Хүн ам

Дорноговь аймгийн хэмжээнд 2020 оны 08 сард 931 эх амаржиж, 8939 хүүхэд шинээр мэндэлж, 223 хүн нас барсан байна. Амаржсан эхийн тоо өмнөх оны мөн үеэс 84(9.9%)-өөр, төрсөн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеэс 89(10.5%)-өөр тус тус өсч, нас барсан хүний тоо өмнөх оны мөн үеэс 31(12.2%)-ээр буурсан байна.

Хүн амын цэвэр өсөлт 716 болж 2019 оны мөн үеийнхээс 120(20.1%)-оор өссөн байна. 1000 хүнд ногдох төрөлт 13.4, нас баралт 3.2 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 1.1 пунктээр өсч, нас баралт өмнөх оны мөн үеэс 0.5 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2017-2020 оны 08 сард



Он гарсаар нялхсын эндэгдэл 10 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.5 дахин өсчээ.



1.2 Эрүүл мэнд


2020 оны эхний 08 сарын байдлаар 260.1 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурч, 11.7 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар, 7.5 мянган хүн урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан нь өмнөх оны мөн үеэс 2.7 хувиар тус тус өсчээ.

2020 оны эхний 08 сард 1181 эх жирэмсний хяналтанд орсны 90.5 хувь буюу 1069 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ. Жирэмсний хяналтанд хугацаандаа орсон эхийн эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.3 пунктээр өссөн байна.

Түргэн тусламжийн дуудлага 13.0 мянган удаа гарсны 2.3 мянга буюу 17.7 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал алсын дуудлага өмнөх оны мөн үеэс 9.5 хувиар өсч, нийт түргэн тусламжийн дуудлага өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар буурсан байна.

Он гарсаар ослын улмаас 1994 хүн бэртэж, 38 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал бэртэж гэмтсэн хүний тоо 155(7.2%)-аар, нас барсан хүний тоо 15(28.3%)-аар тус тус буурсан.

Зураг. Нас баралт, өвчний шалтгаанаар, хувь. 2020 оны 08 сард



Нас баралтыг өвчний шалтгаанаар авч үзэхэд хавдар 26.5 хувь, цусны эргэлтийн тогтолцооны өвчин 25.6 хувь, осол, гэмтэл хордлого гадны шалтгаант үхэл өвчин 17.0 хувь, хоол шингээх эрхтний өвчин 9.0 хувь, дотоод шүүрэл, тэжээлийн ба бодисын солилцооны өвчин 6.3 хувь, бусад төрлийн өвчин 15.7 хувийг тус тус эзэлж байна.

Халдварт өвчний 478 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 214-өөр буюу 30.9 хувиар буурчээ. Халдварт өвчний тохиолдол буурахад трихоминиаз 43.6 хувиар, тэмбүү 34.1 хувиар, заг хүйтэн 24.1 хувиар, сүрьеэ 18.0 хувиар, бусад төрлийн өвчин 44.2 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлжээ.




1.3 Бүртгэлтэй ажилгүй иргэн

Хөдөлмөрийн хэлтэст ажил хайж бүртгүүлсэн иргэд 2020 оны 08 сарын эцэст 363 болсны 310 (85.4%) нь бүртгэлтэй ажилгүй иргэд, 53 (14.6%) нь ажилтай боловч өөр ажил хайж байгаа иргэд байна.

Нийт бүртгэлтэй ажилгүй иргэд нь өмнөх оны мөн үеийнхээс 225 (38.3%) хүнээр, өмнөх сараас 48 (11.7%) хүнээр тус тус буурчээ.

Бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 198(54.5%) нь бүрэн дунд, 98(27%) нь дээд, 21(5.8%) нь тусгай дунд, 17(4.7%) нь бүрэн бус дунд, 19(5.2%) нь техник мэргэжлийн, 6(1.7%) боловсролгүй, 3(0.8%) бага боловсролтой, 1(0.3%) магистр, докторын боловсролтой иргэд эзэлж байна.

Зураг. Ажилгүй иргэдийн тоо, боловсролоор, хувиар, 2020 оны 08 сарын эцэст




Хөдөлмөрийн хэлтэст 2020 оны эхний 8 сарын байдлаар 399 иргэн шинэ ажлын байранд орж, бүртгэлтэй байсан 137 иргэн ажилд зуучлагдан орж, өмнөх сарын бүртгэлээс 133 иргэн ажил идэвхтэй хайхгүй байгаа шалтгаанаар хасагдсан байна.



1.4 Нийгмийн даатгал, халамж


Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээллээр нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 08 сарын байдлаар 27249.2 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 203.8 (0.7%) сая төгрөгөөр буурсан байна. Нийгмийн даатгалын сангийн орлого 2020 оны 08 сард өмнөх оны мөн үеэс 203.8 сая төгрөгөөр буурахад ҮОМШӨ*-ний даатгал 890.9 (31.0%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгал 335.3(42.2%) сая төгрөг, тэтгэмжийн даатгал 49.9(2.5%) сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2020 оны 08 сард



Нийгмийн даатгалын сангийн зарлага 39404.4 сая.төг болж өмнөх оны мөн үеэс 5955.1(17.8%) сая.төгрөгөөр өссөн байна. Зарлагыг бүтцээр нь авч үзвэл тэтгэврийн даатгалын сангаас 29194.3(74.1%) сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 4908.2(12.5%) сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 2341.3(5.9%) сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 1853.5(4.7%) сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 1107.1(2.8%) сая төгрөгийг зарцуулжээ.

Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, сая төг






Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын мэдээллээр нийгмийн халамжийн сангаас 2020 оны 08 сард нийгмийн халамжийн сангаас 22549 иргэнд 5815.1 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Өмнөх онтой харьцуулахад халамж авсан иргэд 876(3.7%)-аар буурч, олгосон тэтгэвэр тэтгэмж 236.5(4.2%) сая төгрөгөөр өссөн байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2020 оны 08 сард 1351 хүн хамрагдсан нь өмнөх оноос 23(1.7%)-аар буурч, олгосон тэтгэвэрийн хэмжээ 682.6(40.1%) сая төгрөгөөр өсчээ.


Нийгмийн нөхцөлт мөнгөн тусламжийг 1134 иргэнд 738.4 сая төгрөг, онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг 1031 иргэнд 575.3 сая төгрөг тус тус олгож, нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургахад 7670 иргэнийг хамруулж, 718.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бусад төрлийн халамжийн үйлчилгээнд 11363 иргэн хамрагдаж, 1398.8 сая төгрөгийг олгожээ.

Зураг. Хүний тоо



Зураг. Олгосон тэтгэвэр, тэтгэмж /сая. төг/






1.5 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр 2020 оны эхний 08 сарын байдлаар 278 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 67 хүн гэмтэж, 15 хүн нас барсан байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 114 (29.1%)-өөр, гэмтсэн хүний тоо 85 (55.9%) -аар, нас барсан хүний тоо 4 (21.1%)-өөр тус тус буурсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийг төрлөөр нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 3(2.0%)-аар, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг 4(36.4%)-өөр, хүн амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 1(10.0%)-ээр тус тус өсч, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг 73(60.3%)-аар, хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 13(59.1)-аар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 16(48.5%)-аар, улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг 10(45.5 %)-аар, авилгын гэмт хэрэг 3(75.0%)-аар тус тус буурч, үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, цэргийн албаны эсрэг гэмт хэрэг, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сараар




Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 54.7 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 17.3 хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулсан гэмт хэрэг, 6.1 хувийг хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, 5.4 хувийг хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, 4.3 хувийг улсын хилээр хууль бусаар эд зүйлс нэвтрүүлсэн гэмт хэрэг, 4.0 хувийг хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг, 8.2 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 45 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 54(54.5%)-өөр буурсан байна.



Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Мандах, Өргөн, Улаанбадрах сумдад нэмэгдэж, Сайхандулаан, Хөвсгөл сумдад өмнө онтой адил, бусад сумдад гэмт хэргийн тоо буурсан байна.


Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, сумаар



Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 1796.3 сая төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1052.1(37.0%) сая төгрөгөөр буурсан байна. Учирсан хохирлын 484.5(26.9%) сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 82(29.5%) нь гэр орон сууцандаа, 45(16.2%) нь согтуугаар, 36(12.9%) нь гудамж олон нийтийн газарт, 28(10.1%) бүлэглэн, 30(10.8%) хувийг эмэгтэй хүн болон хүүхэд оролцон, 82(29.5%) нь шөнийн цагаар /22-06 цагт/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 713 хүн саатуулагдаж, 162 хүн баривчлагджээ.

Зураг. Бүртгэгдсэн гэмт хэргийн бүтэц, хэрэг үйлдэгдсэн цагаар 2020 оны 08 сард




Хоёр. Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт




2.1 Мөнгө, банк

Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын зээлдэгчийн тоо 36.7 мянга болж өмнөх оноос 2.4(7.0%) мянган хүнээр өсч, нийт хадгаламжийн данс эзэмшигчийн тоо 75.8 мянга болж өмнөх оны мөн үеээс 4.7 хувиар өссөн байна.

Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2019-2020 он, сая.төг



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2019-2020 он, мян.хүн




Нийт хадгаламжийн үлдэгдэл 139.7 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчид дунджаар 1843.0 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 2007.1 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Хадгаламжийн үлдэгдлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7(25.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.


Хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл сарын эцэст 6.7 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 0.2(3.9%) тэрбум төгрөгөөр буурч, өмнөх оны мөн үеэс 1.6(30.3%) тэр бум төгрөгөөр өсжээ. Хугацаа хэтэрсэн зээлийн өрийн үлдэгдэл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 2.6 хувийг эзэлж, өмнөх сараас 0.1 пунктээр өсж, өмнөх оны мөн үеэс 0.8 пунктээр өсчээ.

Чанаргүй зээл сарын эцэст 12.8 тэрбум төгрөг болж өмнөх сараас 1.1(9.5%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 5.7(79.6%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Чанаргүй зээл нийт зээлийн өрийн үлдэгдлийн 4.9 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеэс 2.4 пунктээр өссөн байна.

Зураг. Зээл төрлөөр, дүнд эзлэх хувиар, 2020.08 сард




Зураг. Зээлдэгчийн тоо, зээлийн төрлөөр, 2020.08 сард



2.2 Төсөв, санхүү

2020 оны 08 дугаар сарын байдлаар орон нутгийн төсөвт 24040.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 75.9 хувь байна. Өмнөх оны мөн үетэй төсвийн орлогын дүнг харьцуулахад 0.3 хувиар буурсан байна / 2020 оны орон нутгийн төсвийн орлогод улсын төсөв, орон нутгийн төсөв хоорондын шилжүүлсэн орлогын дүн тусгагдаагүй/. Аймгийн орон нутгийн төсвийн орлогын 75.9 хувийг татварын, 24.1 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

Зураг. Орон нутгийн төсвийн орлого, зарлагын бүтэц, хувиар, 2020 оны 08 сард



Улсын нэгдсэн төсөвт ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх нөөц ашигласны төлбөр, ус бохирдуулсны төлбөр нийт 5821.4 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна. Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын дүнг өмнөх оны мөн үеэс 11.3 хувь буюу 590.7 сая.төг-өөр, төлөвлөгөөнөөс 7.6 хувь буюу 413.2 сая.төг-өөр давуулан биелүүлсэн байна.



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2020 оны 08 дугаар сарыг өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 3.6 хувиар тус тус өсчээ.

Ерөнхий индекс өмнөх сартай харьцуулахад 0.7 хувиар буурахад: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 3.1 хувиар буурсан нь нөлөөлсөн байна.


Ерөнхий индекс өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.6 хувиар өсөхөд: хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлэг 9.2 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлэг 1.9 хувь, хувцас бөс бараа, гутлын бүлэг 6.0 хувь, орон сууц, ус, цахилгаан, түлшний бүлэг 1.7 хувь, гэр ахуйн тавилгын бүлэг 6.4 хувь, эм тариа эмнэлэгийн үйлчилгээний бүлэг 2.0 хувь, холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээний бүлэг 0.1 хувь, амралт чөлөөт цаг соёлын барааны бүлэг 0.1 хувь, зочид буудал, зоогийн газар, дотуур байрны үйлчилгээний бүлэг 3.4 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.




Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2020 оны 08 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2019-2020 оны үнийн өөрчлөлт, сар бүрээр (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2016 -2020 оны 08 дугаар сар (өмнөх оны 12-р сар=100)



Гурав. Эдийн засгийн статистикийн үзүүлэлт




3.1 Хөдөө аж ахуй

Аймгийн хэмжээнд 2019 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 1010.6 мянган хээлтэгч малын 728.5 мянга (72.1%) нь 2020 оны эхний 8 сард төллөсөн байна. Эм хонины 80.3 хувь, эм ямааны 68.9 хувь, ингэний 46.2 хувь, үнээний 55.9 хувь, гүүний 47.4 хувь нь төллөжээ.

Гарсан төлийн 99.9 хувь буюу 732.8 мянган төл бойжиж байна. Бойжуулсан төл өмнөх оны мөн үеэс 53.3 (7.8%) мянгаар илүү байна. Дэлгэрэх суманд 77.7 мянга, Айраг суманд 67.1 мянга, Даланжаргалан суманд 66.6 мянга, Хатанбулаг суманд 61.8 мянган, Иххэт суманд 60.6 мянган төл тус тус бойжсон нь нийт бойжсон төлийн 45.5 хувийг эзэлж байна.

Том малын зүй бус хорогдол 2020 оны эхний 8 сард аймгийн хэмжээнд 894 болж, өмнөх оны мөн үеэс 3429(79.3%) толгойгоор буурсан байна. Нийт хорогдсон малын 56.8 хувийг ямаа, 30.3 хувийг хонь эзэлж байна.

Зураг. Том малын зүй бусын хорогдол, жил бүрийн 08 сард



Малын зах зээлийн дундаж үнийн мэдээгээр нас гүйцсэн ат Улаанбадрах суманд хамгийн их буюу 1500.0 мянган төгрөг, Дэлгэрэх, Эрдэнэ сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг, соёолон үрээ Өргөн суманд их буюу 1100.0 мянган төгрөг, Сайхандулаан суманд хамгийн бага буюу 700.0 мянган төгрөг, хязаалан гуна Алтанширээ суманд хамгийн их буюу 2000.0 мянган төгрөг, Сайхандулаан, Эрдэнэ, Сайншанд сумдад хамгийн бага буюу 1000.0 мянган төгрөг байна. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ Сайхандулаан суманд хамгийн их буюу 220.0 мянган төгрөг, Хатанбулаг, Сайншанд сумдад хамгийн бага буюу 150.0 мянган төгрөг, нас гүйцсэн эр ямааны дундаж үнэ Сайхандулаан суманд хамгийн их буюу 180.0 мянган төгрөг, Иххэт суманд хамгийн бага буюу 100.0 мянган төгрөг байна.



3.2 Аж үйлдвэр

Оны эхний 08 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарт 113897.2 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 176001.5 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 13.0 хувиар, борлуулалт 18.9 хувиар тус тус буурсан байна.

2020 оны 08 сарын байдлаар аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлт 13.0 хувиар буурахад уул, уурхай олборлох салбарын үйлдвэрлэлт өмнөх оноос 28386.7 сая төгрөгөөр, боловсруулах салбарын үйлдвэрлэлт 1047.0 сая төгрөгөөр тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 4.3 хувийг төрийн, 95.7 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэжээ.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 4.3 хувь, компани 95.2 хувь, өрхийн аж ахуй 0.5 хувийг тус тус эзэлж байна.

Статистикийн мэдээлэлд хамрагдсан гол нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ус түгээлт 46.9 мян.м3-оор, сувагжуулалт 21.2 мян.м3-аар, талх 120.4 тонноор, бялуу 0.7 тонноор, хэрчсэн гурил 25.0 мян.тн-оор, цемент 63.3 мян.тонноор, шохой 2450 тонноор, вакуум цонх 29.8 м2-аар, модон эдлэл 12942.5 мян.төгрөгөөр, хайрга 3.2 мян.м3-аар тус тус илүү үйлдвэрлэгджээ.

Дөрөв. Байгаль орчны статистикийн үзүүлэлт



4.1 Байгаль орчин

Цаг уур

Температур: Сарын дундаж агаарын температур Мандах, Айраг, Дэлгэрэх, Иххэт сумдад 18.0...19.8 градус дулаан, бусад сумдын нутгаар 20.2...22.9 градус дулаан, агаарын хамгийн их температур өдөртөө нийт сумдад 31...35 градус, 30 градусаас дулаан хоногийн тоо Замын-Үүд, Хөвсгөл сумдад 10...12, бусад сумдад 1...5 өдөр байлаа. Агаарын дундаж температурыг олон жилийн дундаж / ОЖД /-тай харьцуулахад: Эрдэнэ, Өргөн, Дэлгэрэх, Алтанширээ сумдад олон жилийн дунджаас 1.3...2.1 градусаар хүйтэн, бусад сумдад ОЖД-ийн орчим байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 7...11 градус дулаан, өдөртөө нийт сумдад 50...61 градус дулаан байв.

Хур тунадас: Сарын нийлбэр хур тунадас Хөвсгөл суманд хамгийн бага буюу 21.7 мм, бусад сумдын нутгаар 49.2...177.7 мм орсон байна. Сарын нийлбэр хур тунадсыг олон жилийн дундажтай харьцуулахад Хөвсгөл суманд олон жилийн дундажийн орчим, бусад сумдад олон жилийн дундажаас ахиу байлаа.



Салхи: Энэ сард салхины хамгийн их хурд Сайншанд, Замын-Үүд, Мандах, Хөвсгөл, Эрдэнэ сумдын нутгаар секундэд 18...24 метр хүрч аюултай болон онц аюултай үзэгдлийн хэмжээнд ажиглагдсан байна. 10м/с-ээс дээш салхитай 3...16 өдөр байлаа.

Бэлчээрийн ургамал: 8 дугаар сарын 25-ны байдлаар бэлчээрийн ургамлын дундаж өндөр 7-20 см, бэлчээрийн ургамлын ургалтын байдал сумын нутгийн 4 зүгийн үнэлгээгээр Мандах, Сайхандулаан сумдын өмнө, Улаанбадрах, Хөвсгөл, Хатанбулаг сумдын хойд хэсгээр дунд, бусад нутгаар сайн байна.

МАА-н үйлдвэрлэлд: Цаг агаарын нөхцлөөс болж малын бэлчээрлэлт саатсан тохиолдол гараагүй.

_____ о О о _____



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2020 ОНЫ 08 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	Хэмжих нэгж	2017	2018	2019	2020	2020 2019
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	мянган хүн	68.2	68.5	70.0	70.6	100.9
- Төрсөн хүүхдийн тоо**	тоо	830	902	850	939	110.5
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	тоо	232	264	254	223	87.8
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	тоо	598	638	596	716	120.1
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	тоо	6	11	4	10	2.5 ²
- 1000 хүүхдэд ноогдох	тоо	7.2	12.2	4.7	10.6	2.3 ²
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	тоо	1 705	734	588	363	61.7
- Үүнээс эмэгтэй	тоо	841	337	296	184	62.2
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	тоо	402	170	136	85	62.3
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	тоо	302	213	63	399	6.3 ²
Үүнээс: Байнгын ажлын байр	тоо	302	87	45	145	3.2 ²
Улирлын чанартай ажлын байр	тоо	0	126	18	20	111.1
Түр ажлын байр					234	
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	тоо	532	484	692	417	60.3
- 10000 хүнд ногдох	тоо	78	70	99	59	59.1
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	тоо	445	353	392	278	70.9
- 10000 хүнд ногдох ***	тоо	104	82	88	63	70.9
6.Бойжиж буй төл	толгой	571231	591946	679524	732820	107.8
- Унага	толгой	18331	19003	18663	23633	126.6
- Тугал	толгой	13737	15858	14566	20497	140.7
- Ботго	толгой	6342	6512	6953	7927	114.0
- Хурга	толгой	283809	292632	339672	364724	107.4
- Ишиг	толгой	249012	257941	299670	316039	105.5
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн	сая төгрөг	89580.5	134240.4	130982.6	113897.2	87.0
- Борлуулсан бүтээгдэхүүн	сая төгрөг	145349.5	196299.4	217145.5	176001.5	81.1

* - 2017,2018,2019 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.



НЭГ. ЭРҮҮЛ МЭНД

1.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

	Хэмжих нэгж	2019 I-VIII	2020 I-VIII	Өсөлт	
		тоо		хувь	
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	261.6	260.1	-1.5	99.4
2. Ор хоног	мян.хүн	80.6	81.4	0.8	101.0
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	7.3	7.5	0.2	102.7
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	11.3	11.7	0.4	103.5
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	13.3	13.0	-0.3	97.7
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	2.1	2.3	0.2	109.5
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	2149	1994	-155	92.8
Үүнээс: нас баралт	хүн	53	38	-15	71.7
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	1250	1181	-69	94.5
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	1102	1069	-33	97.0
8. Амаржсан эх	хүн	847	931	84	109.9
Үүнээс: нас баралт	хүн	0	1	1	0.0
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	2	1	-1	50.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	4	10	6	2.5 ²

1.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар, жил бүрийн 08 сард

Сумын нэр	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
				хүртэл насандаа эндсэн хүүхэд	
тоо					
Дүн	931	1	939	10	0
Айраг	1		1		
Алтанширээ	1		1		
Даланжаргалан	1		1		
Дэлгэрэх					
Иххэт					
Мандах	1		1		
Өргөн	1		1		
Сайхандулаан					
Улаанбадрах					
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	1		1		
Эрдэнэ	2		2	1	
Сайншанд	726	1	734	7	
Замын - Үүд	196		196	2	

Эх үүсвэр: Аймгийн Эрүүл мэндийн газар



1.3. БҮРТГЭГДСЭН ХАЛДВАРТ ӨВЧИН, төрлөөр, жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2019 I-VIII	2020 I-VIII	Өсөлт	
	тоо	тоо	тоо	хувь
Халдварт өвчний гаралт-Бүгд	692	478	-214	69.1
Вируст гепатит	5	3	-2	0.0
Сүрьеэ	61	50	-11	82.0
Тэмбүү	126	83	-43	65.9
Заг хүйтэн	191	145	-46	75.9
Трихоминиаз	117	66	-51	56.4
Цусан суулга	29	40	11	137.9
Бусад	163	91	-72	55.8

Тайлбар -²-дахин их

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газар



ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

2.1 АЖИЛ ХАЙГЧ ИРГЭНИЙ ТОО, боловсролын түвшингээр, жил бүрийн 08 сард

Боловсролын түвшингээр	2017 VIII	2018 VIII	2019 VIII	2020 VIII	2020 VIII 2017 VIII	2020 VIII 2019 VIII
	хүний тоо				хувь	
ДҮН	1 705	734	588	363	21.3	61.7
Үүнээс: Эмэгтэй	841	337	296	184	21.9	62.2
Магистр, доктор	8	0	3	1	12.5	33.3
Дээд боловсролтой	388	114	69	98	25.3	142.0
Тусгай дунд	159	25	18	21	13.2	116.7
Техник мэргэжлийн	158	45	21	19	12.0	90.5
Бүрэн дунд	781	486	420	198	25.4	47.1
Бүрэн бус дунд	165	40	37	17	10.3	45.9
Бага	23	7	3	3	13.0	100.0
Боловсролгүй	23	17	17	6	26.1	35.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар

2.2 АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар, жил бүрийн 08 сард

	Бүртгэлтэй иргэдийн тоо		Ажилд орсон иргэдийн тоо		Шинээр нэмэгдсэн иргэдийн тоо	
	2019 VIII	2020 VIII	2019 VIII	2020 VIII	2019 VIII	2020 VIII
ДҮН	588	363	313	913	29	1818
Айраг	5	12	2	15	2	52
Алтанширээ	3	5	13	5	0	20
Даланжаргалан	26	8	34	1	0	13
Дэлгэрэх	8	5	5	1	0	12
Иххэт	10	0	5	3	0	10
Мандах	6	20	5	0	0	25
Өргөн	7	5	72	2	0	21
Сайхандулаан	2	19	7	4	1	27
Улаанбадрах	7	2	12	38	0	55
Хатанбулаг	9	22	16	74	0	110
Хөвсгөл	5	7	5	0	0	13
Эрдэнэ	38	13	20	32	2	81
Сайншанд	344	173	58	328	15	805
Замын - Үүд	118	72	59	410	9	574

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал, 2020 оны 08 сарын эцэст

Салбарын ангилал	2019 I-VIII	2020 I-VIII
	Тоо	
Бүгд	336	1211
ХАА, ан агнуур, ойн аж ахуй,загас барилт	24	18
Уул уурхай олборлох аж үйлдвэр	126	4
Боловсруулах үйлдвэрлэл	1	1
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	2	17
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын Барилга	12	41
Бөөний ба жижиглэн худалдаа, машин, мотоциклийн Тээвэр агуулахын үйл ажиллагаа	23	215
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны Мэдээлэл, холбоо	4	9
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	2	7
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	6	20
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7	2
Төрийн удирдлага, батлан хамгаалах, үйл ажиллагаа, Боловсрол	0	377
Хүний эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ	30	46
Урлаг, үзвэр,тоглоом наадам	20	24
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	7	48
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл	1	17
	78	334
		0
		0

2.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал, 2020 оны 08 сарын эцэст

Үзүүлэлт	2019 I-VIII	2020 I-VIII
	Тоо	
Бүгд	336	1211
Менежер	7	27
Мэргэжилтэн	39	476
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	51	59
Контор, үйлчилгээний ажилтан	22	198
Худалдаа, үйлчилгээний ажилтан	17	66
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	1
Үйлдвэрлэл, барилга,гар урлал,холбогдох ажил үйлчилгээний Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	22	111
Энгийн ажил мэргэжил	39	34
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	118	172
	6	67

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



2.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангиллаар жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2019 I-VIII		2020 I-VIII	
	Бүгд	эмэгтэй	Бүгд	эмэгтэй
	тоо		тоо	
Бүгд	313	128	913	531
Менежер	5	4	17	5
Мэргэжилтэн	37	27	409	296
Техникч болон туслах дэд/мэргэжилтэн	48	20	43	28
Контор, үйлчилгээний ажилтан	20	18	185	117
Худалдаа, үйлчилгээний ажилтан	13	11	43	27
ХАА, ой загас агнуурын ажилтан	15	5	1	0
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	21	3	72	18
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	38	1	23	0
Энгийн ажил мэргэжил	111	35	117	39
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	5	4	3	1

2.6 ШИНЭ АЖЛЫН БАЙРАНД ОРСОН ИРГЭН, эдийн засгийн салбарын ангиллаар 2020 оны 08 сард

Салбарын ангилал	Бүгд	Эмэгтэй	Бүгдээс: Ажлын байрны шинж, чанараар		
			Байнга	Улирал	Түр
	тоо				
Бүгд	399	170	145	20	234
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4	3	3	1	
Уул уурхай олборлолт	2	1	1	1	
Боловсруулах үйлдвэрлэл	18	12	14		4
Цахилгаан, хий уур агааржуулалтын хангамж	8	3	8		
Усан хангамж, бохир ус, хог хаягдлын менежмент	31	2	31		
Барилга	61	5	10	16	35
Бөөний ба жижиглэн худалдаа, гэр ахуйн барааны засварлах үйлчилгээ	37	16	17		20
Тээвэр агуулахын үйл ажиллагаа	4	4		2	2
Байр сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	22	17	10		12
Мэдээлэл холбоо	2	1	2		
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1		1		
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0				
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	3	2	3		
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	7	2	2		5
Төрийн удирдлага, батлан хамгаалах, албан журмын даатгал	137	58	5		132
Боловсрол	21	15	21		
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	8	5	8		
Урлаг үзвэр тоглоом наадам	5	5	5		
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	28	19	4		24
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн аж ахуй	0				
Олон улсын байгууллагын үйл ажиллагаа	0				

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар



ГУРАВ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХАЛАМЖ

3.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2019 I-VIII	2020 I-VIII	2020 I-VIII 2019 I-VIII
	сая төгрөг		хувь
Нийгмийн даатгалын сангийн орлого	27 453.0	27 249.2	99.3
Тэтгэврийн даатгалын сан	17337.9	18 379.2	106.0
Тэтгэмжийн даатгалын сан	1965.0	1 915.1	97.5
Эрүүл мэндийн даатгалын сан	4486.7	4 517.7	100.7
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2869.6	1 978.7	69.0
Ажилгүйдлийн даатгалын сан	793.8	458.5	57.8
Нийгмийн даатгалын сангийн зарлага	33 449.3	39 404.4	117.8
Тэтгэврийн даатгалын сан	24789.7	29 194.3	117.8
Тэтгэмжийн даатгалын сан	1930.0	2 341.3	121.3
Эрүүл мэндийн даатгалын сан	4017.9	4 908.2	122.2
ҮОМШӨ*-ний даатгалын сан	2014.1	1 853.5	92.0
Ажилгүйдлийн даатгалын сан	697.6	1 107.1	158.7

3.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ДААТГУУЛАГЧИД, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 08 сард

Үзүүлэлт	2019 I-VIII	2020 I-VIII	2020 I-VIII 2019 I-VIII
	хүн		хувь
1. Нийгмийн даатгалд даатгуулагчид	37936	37636	99.2
Албан журмаар даатгуулагчид	17062	16952	99.4
Аж ахуй нэгж, байгууллага	8892	8666	97.5
Төсөвт байгууллага	8170	8286	101.4
Сайн дураар даатгуулагчид	3812	3732	97.9
2. Тэтгэвэр авагчдын тоо	8611	9178	106.6
Өндөр насны тэтгэвэр	6205	6708	108.1
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	1294	1357	104.9
Тэжээгчээ алдсаны	504	490	97.2
Цэргийн тэтгэвэр	456	475	104.2
ҮОМШӨ*-ний	152	148	97.4
	сая төгрөг		
3. Олгосон тэтгэвэр	21 971.7	29 786.1	135.6
Өндөр насны тэтгэвэр	15 966.5	21 895.2	137.1
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн	2 477.0	3 383.1	136.6
Тэжээгчээ алдсаны	1 092.2	1 328.9	121.7
Цэргийн тэтгэвэр	1 856.0	2 579.5	139.0
ҮОМШӨ*-ний	580.0	599.4	103.3

Тайлбар: *-Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтэс



3.3 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, сумаар

Сумын нэр	2019 I-VIII	2020 I-VIII	2020 I-VIII 2019 I-VIII
	сая төгрөг		хувь
ДҮН	27453.0	27249.2	99.3
Айраг	476.6	413.7	86.8
Алтанширээ	164.5	179.8	109.3
Даланжаргалан	1201.4	1083.9	90.2
Дэлгэрэх	198.3	201.5	101.6
Иххэт	355.3	316.3	89.0
Мандах	221.3	203.5	92.0
Өргөн	986.2	461.5	46.8
Сайхандулаан	224.7	212.8	94.7
Улаанбадрах	210.1	251.7	119.8
Хатанбулаг	464.1	543.6	117.1
Хөвсгөл	208.9	217.1	103.9
Эрдэнэ	387.2	435.1	112.4
Сайншанд	15308.1	15470.7	101.1
Зүүнбаян баг	794.3	949.8	119.6
Замын-Үүд	6252	6308.2	100.9

3.4 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА, сумаар

Сумын нэр	2019 I-VIII	2020 I-VIII	2020 I-VIII 2019 I-VIII
	сая төгрөг		хувь
ДҮН	33449.3	39404.4	117.8
Айраг	1652.5	1860.0	112.6
Алтанширээ	624.3	718.7	115.1
Даланжаргалан	1504.1	1606.7	106.8
Дэлгэрэх	691.0	856.1	123.9
Иххэт	1195.7	1324.1	110.7
Мандах	693.5	830.8	119.8
Өргөн	1294.0	1215.8	94.0
Сайхандулаан	464.8	603.5	129.8
Улаанбадрах	748.1	847.5	113.3
Хатанбулаг	1300.0	1464.4	112.6
Хөвсгөл	613.1	726.0	118.4
Эрдэнэ	1118.3	1313.9	117.5
Сайншанд	13887.7	17221.9	124.0
Зүүнбаян баг	1228.9	1387.1	112.9
Замын-Үүд	6433.3	7427.9	115.5



3.5 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр, жил бүрийн 08 сарын эцэст

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-VIII 2019 I-VIII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-VIII 2019 I-VIII
	2019 I-VIII	2020 I-VIII		2019 I-VIII	2020 I-VIII	
	тоо		хувь	сая төгрөг		хувь
НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГИЙН ЗАРЦУУЛАЛТ	23425	22549	96.3	5578.6	5815.1	104.2
1. Халамжийн тэтгэвэр	1374	1351	98.3	1701.1	2383.7	140.1
Ахмад настны тэтгэвэр	78	98	125.6	92.1	169.2	183.8
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр	1296	1253	96.7	1609.0	2214.5	137.6
2 Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1046	1134	108.4	548.9	738.4	134.5
Эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай, ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүнийг асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхлэдэггүй хөдөлмөрийн насны иргэнд олгосон тэтгэмж	987	1077	109.1	515.3	700.4	20.5
Бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон асран хамгаалж харгазан дэмжиж байгаа иргэнд олгох тэтгэмж	50	52	104.0	28.5	35.0	122.8
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан болон хүчирхийллийн улмаас хамгаалалт шаардлагатай болсон хүүхдийг мөн хуулийн 74 дүгээр зүйлд заасны дагуу гэр бүлдээ авч асрамжилж байгаа иргэнд олгох тэтгэмж	7	5	71.4	3.9	3.0	76.7
Ахмад настаныг гэртээ асрамжилж байгаа иргэн	2	0	0.0	1.2	0.0	0.0
Байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэн		0		0.0	0.0	
3. Онцгой тохиолдлын болон амжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн дүн	936	1031	110.1	384.5	575.3	149.6
16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хүүхдэд олгох мөнгөн тэтгэмж	225	241	107.1	270.1	428.3	158.6
Байнгын асаргаа шаардлагатай 16-с дээш насны иргэн	678	745	0.0	72.8	85.0	0.0
Гурав ба түүнээс дээш тооны бага насны /14 хүртэлх насны/ хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/			0.0	0.0	0.0	0.0
2 ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа өрх, иргэнд олгох тэтгэмж	7	10	0.0	14.0	20.0	0.0



Хүснэгт 3.5-ийн үргэлжлэл

Үзүүлэлт	Хамрагдсан хүний тоо		2020 I-VIII 2019 I-VIII	Олгосон тэтгэвэр тэтгэмж		2020 I-VIII 2019 I-VIII
	2019 I-VIII	2020 I-VIII		2019 I-VIII	2020 I-VIII	
	тоо		хувь	мянган төгрөг	хувь	
18 нас хүрээгүй байхдаа бүтэн өнчин болсон 18-24 насны иргэн	5	5	0.0	6.0	6.0	0.0
Гэнэтийн аюул, ослын улмаас орон гэргүй болсон өрх	17	27	0.0	20.4	32.4	0.0
Хорих ангиас суллагдсан өөрийн гэр оронгүй иргэн	1	1	0.0	1.2	1.2	0.0
Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай, 4 ба түүнээс дээш 18 хүртэлх насны хүүхэдтэй, гэр оронгүй, өрх толгойлсон иргэн	3	2	0.0	3.6	2.4	0.0
4. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний зардал	0	0	0.0	0	0	0.0
5. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай НХТХууль 3.1.2, 18.2-т заасан өрх, иргэнийг нийгэмшүүлэх, хамт олны бүлэг бүрдүүлэх, орлогын эх үүсвэртэй болгох төсөл хэрэгжүүлэх, амьдрах ухаанд сургах зардал	8729	7670	87.9	643.6	718.9	111.7
Ахмад настанд үзүүлсэн тусламж, хөнгөлөлтийн зарцуулалт	3486	2542	72.9	142.1	161.6	113.7
Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусламж, хөнгөлөлт	190	227	119.5	63.4	55.7	87.9
Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүн, сум, хорооны нийгмийн ажилтанд олгох урамшил	0	84	0.0	0.7	2.5	0.0
Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалт	3822	3650	95.5	282.9	473.1	2.7 ²
Банкны шимтгэл				3.3	2.7	0.0
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхийн тэтгэмжийн зарцуулалт	1231	1167	94.8	151.2	23.3	15.4
6. Бусад халамжийн дүн	11340	11363	100.2	2300.5	1398.8	60.8
Алдарт эхийн одонгийн тусламж	4949	4949	100.0	655.5	632.3	96.5
